

**МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ**

2024 оны дүгээр  
сарын ....-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

**Тариф батлах тухай**

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Замын-Үүдийн дулааны станц” ТӨҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 1/439 тоот албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тарифыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Замын-Үүдийн дулааны станц” ТӨҮГ (О.Төмөрхуяг)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар /Б.Эрдэнэбулган/-т даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 219 дүгээр тогтоолын хавсралтын 1 дүгээр мөрөнд заасан “Төсөвт байгууллагын халаалт”-ын тарифуудыг хүчингүй болгосугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны  
2024 оны .. дүгээр сарын ...-ний өдрийн  
....дүгээр тогтоолын хавсралт

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМЫН ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГАД  
БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын төсөвт байгууллагад борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчдийн ангилал		Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/	
1	Төсөвт халаалт байгууллагын	Эзлэхүүнээр	төг/м <sup>3</sup>	2,350.0	
		Хэмжүүрээр	хувьсах	төг/ГЖ	23,697.5
			тогтмол	төг/м <sup>3</sup>	1,718.4

--oOo--